

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХНИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Б.ОТГОНСҮХ



**“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХНИЙ
АЖИЛЧДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛАХ
СПОРТЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

2024 оны 04 дүгээр
сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО

1.1. Компанийн ажилчдыг нэгдэн нягтрах, идэвхтэй хөдөлгөөн, спортоор тогтмол хичээллэж бие бялдраа чийрэгжүүлэх, амьдралын зөв дадал төлөвшүүлэх, газар, хэлтэс, алба, салбар нэгж тус бүрээс шалгарсан шилдэг тамирчдаас бүрдсэн компанийн шигшээ багийг бүрдүүлэхэд оршино.

ХОЁР. ТЭМЦЭЭНИЙ ТӨРӨЛ, ХУГАЦАА

- 2.1. **Зохион байгуулагч:** Спорт зөвлөл, Захиргаа удирдлагын газар
- 2.2. **Хамрах хүрээ:** Төв оффис, Цогтцэций өртөө, Төмөртэй өртөө
- 2.3. **Хэзээ:** 2024 оны 04-р сарын 26, 27, 28-ны өдөр зохион байгуулагдана.
- 2.4. **Тэмцээний төрөл:**
 - 2.5.1. Шатар
 - 2.5.2. Биллярд
 - 2.5.3. Дартсын тэмцээн
 - 2.5.4. Сагсан бөмбөг
 - 2.5.5. Волейбол

ГУРАВ. ТЭМЦЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1. 2024 оны 04 дугаар сарын 26-нд Шатар, Биллярд, Дартс, 04 дугаар сарын 27-нд Волейбол, 04 дугаар сарын 28-нд Сагсан бөмбөгийн төрлүүд зохион байгуулагдана.

3.2. Тэмцээн төрөл тус бүр дараах дүрмийн дагуу зохион байгуулагдана.

3.3. Шатар:

3.3.1. Тэмцээний шатрын төрөлд /эрэгтэй, эмэгтэй тус бүр/ Төв оффис – 4, Цогтцэций өртөө – 4, Төмөртэй өртөө – 4 хүртэл тамирчныг “Play Off” тоглолтод оролцуулна.

3.3.2. Тэмцээнийг олон улсын шатрын холбоо /FIDE/ болон Монголын шатрын холбооны дүрмийн дагуу зохион байгуулна.

3.3.3. Цагийн хяналт талдаа 10 минут байна.

3.3.4. Оролцогчдын тооноос хамааран 10 хүртэл тамирчин оролцвол тойргийн систем, түүнээс дээш бол 7 өргийн швейцарь систем ашиглана.

3.4. Биллярд:

3.4.1. Тэмцээний эрэгтэй биллярдын төрөлд Төв оффис – 16, Цогтцэций өртөө – 4, Төмөртэй өртөө – 2, эмэгтэй биллярдын төрөлд Төв оффис – 3, Цогтцэций өртөө – 3, Төмөртэй өртөө – 2 хүртэл тамирчныг “Play Off” тоглолтод оролцуулна.

3.4.2. Эрэгтэй “Snooker Billiard” төрлөөр Азийн бильярддын холбооны албан ёсны 6 улааны дүрмээр явагдана.

3.4.3. Эмэгтэй “Pool Billiard” төрлөөр Олон улсын Чайниз Эйтбол буюу 8 бөмбөгийн дүрмээр явагдана.

3.4.4. Тэмцээнийг зохион байгуулагчаас томилсон шүүгч шүүнэ.

3.5. Дартс:

3.5.1. Тэмцээний дартсын төрөлд эрэгтэй Төв оффис – 4, Цогтцэций өртөө – 4, Төмөртэй өртөө – 2 шигшээ багийг бүрдүүлж “Play Off” тоглолтод оролцуулна.

3.5.2. Нэг баг эрэгтэй 2, эмэгтэй 1 гишүүнтэй оролцоно.

3.5.3. Тэмцээнийг зохион байгуулагчаас томилсон шүүгч шүүнэ.

3.5.4. Тоглогчид ээлжлэн 3,3 сум шидэж өрсөлдөх бөгөөд 501 онооноос эхэлж авсан оноогоо хасах журмаар тоглон хоёрын үржвэрээр тэглэж дуусгана.

3.5.5. 45 сумаар дуусаагүй тохиолдолд бухын нүд рүү хэн ойрхон шидсэнээр хожлыг өгнө.

3.5.6. Хэрэв өрсөлдөгч нар тойргоор бие биеэ хожиж хожлын харьцаа тэнцвэл багийн 4 гишүүний сумны нийлбэр оноогоор хожлын оноог шийдвэрлэнэ.

3.5.7. Тамирчид шүүгч болон өрсөлдөгчдөө оноогоо гүйцэт харуулсны дараа сумаа самбараас авна. Хэрэв гүйцэт харуулалгүйгээр сумаа авсан тохиолдолд авсан 3 сумны нийлбэр оноог тооцохгүй.

3.6. Сагсан бөмбөг:

3.6.1. Тэмцээний Сагсан бөмбөгийн төрөлд эрэгтэй Төв оффис – 3, Цогтцэций өртөө – 4, Төмөртэй өртөө – 1, эмэгтэй Төв оффис – 1, Цогтцэций өртөө – 2, Төмөртэй өртөө – 1 хүртэл шигшээ багийг бүрдүүлж “Play Off” тоглолтод оролцуулна.

3.6.2. Нэг баг эрэгтэй, эмэгтэй тус бүр 8 гишүүнтэй байна.

3.6.3. Эрэгтэй багийн тоглолт 8 минутаар 2 үе, Эмэгтэй багийн тоглолт 6 минутаар 2 үе тоглох ба 2-р үеийн сүүлийн 2 минут цэврээр явагдана. Торгуулийн шидэлт хийхэд цаг зогсоно.

3.6.4. Тэмцээнийг Монголын сагсан бөмбөгийн холбооны мэргэжлийн шүүгч шүүнэ.

3.6.5. Удирдамжид тусгагдаагүй бусад асуудлыг техникийн зөвлөгөөн дээр нарийвчлан ярилцана.

3.7. Волейбол:

3.7.1. Тэмцээний Волейболын төрөлд эрэгтэй Төв оффис – 3, Цогтцэций өртөө – 4, Төмөртэй өртөө – 1, эмэгтэй Төв оффис – 1, Цогтцэций өртөө – 2, Төмөртэй өртөө – 1 хүртэл шигшээ багийг бүрдүүлж “Play Off” тоглолтод оролцуулна.

3.7.2. Нэг баг эрэгтэй, эмэгтэй тус бүр 8 гишүүнтэй байна.

3.7.3. Хэсгийн тоглолтууд 21 оноогоор, медалийн төлөөх тоглолтууд 25 оноогоор 2 ээлж тоглох ба 1-1 болж тэнцвэл 3 дахь ээлж 15 тоогоор явагдана.

3.7.4. Тэмцээнийг Олон улсын волейболын холбооны дүрмийн дагуу Монголын волейболын холбооны мэргэжлийн шүүгч шүүнэ.

3.7.5. Удирдамжид тусгагдаагүй бусад асуудлыг техникийн зөвлөгөөн дээр нарийвчлан ярилцана.

ДӨРӨВ. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

4.1. “Play Off” тоглолтод тэмцээний төрөл тус бүр дээр 1,2,3 дугаар байр эзлүүлэн шагнаж урамшуулна.

4.2. Шагнал урамшуулал төрөл тус бүрд

1-р байр: Алтан медаль, Өргөмжлөл, мөнгөн шагнал

2-р байр: Мөнгөн медаль, Өргөмжлөл, мөнгөн шагнал

3-р байр: Хүрэл медаль, Өргөмжлөл, мөнгөн шагнал

4.3. Тэмцээний багийн төрөлд оролцсон хувь тамирчны ур чадварыг харгалзан дараах байдлаар Шилдгүүдийг шалгаруулна.

- Шилдэг тоглогч – 2 /эр, эм/ Өргөмжлөл, мөнгөн шагнал
- Шилдэг холбогч – 2 /эр, эм/ Өргөмжлөл, мөнгөн шагнал
- Шилдэг хамгаалагч – 2 /эр, эм/ Өргөмжлөл, мөнгөн шагнал

ЗУРГАА. ТЕХНИКИЙН ЗӨВЛӨГӨӨН, МЭДҮҮЛЭГ ХҮЛЭЭН АВАХ

6.1. Техникийн зөвлөгөөн 2024 оны 04 дугаар сарын 19-ны өдөр төв оффист 14.00 цагт болно. Цогтцэций өртөө, Төмөртэй өртөөний багууд онлайнгаар оролцож болно.

6.2. Техникийн зөвлөгөөнд эрэгтэй, эмэгтэй багийн ахлагч нар оролцоно.

6.3. Техникийн зөвлөгөөн дээр тэмцээний нарийвчилсан дүрмийг танилцуулж тэмцээний тоглолтын хуваарийг сугалаа сугалуулж шийднэ.

6.4. Тэмцээнд оролцох багийн мэдүүлгийг Хавсралт 1-ийн дагуу бөглөж 2024 оны 04 сарын 22-ны өдөр erdenebayar@mtz.mn хаягаар хүлээн авна.

ДОЛОО. ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ БАГ ТАМИРЧДАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

7.1. Тэмцээнд оролцож байгаа багийн тоглогч нь тус байгууллагад үндсэн гэрээгээр ажилладаг, нийгмийн даатгалын шимтгэлийг 1 буюу түүнээс дээш сараар төлсөн байх шаардлагатай бөгөөд 1 тамирчин 2-оос илүү төрөлд оролцохгүй.

7.2. Баг тамирчид ижил өнгөтэй, хувийн дугаартай хувцсаар жигдэрсэн байна.

7.3. Зохион байгуулагч нь тухайн ажилтныг шалгаж, удирдамжид заагдсан шаардлага хангаагүй тохиолдолд тухайн тоглогчийг тэмцээнээс хасах эрхтэй.

7.4. Тухайн баг нь тэмцээний шаардлагад заасан хориглох тамирчныг мэдсээр байж талбайд гаргасан бол тухайн багийн тэмцээнээс хасна.

НАЙМ. БУСАД

8.1. Тэмцээний удирдамжид тусгаагүй асуудлыг техникийн зөвлөгөөн болон тэмцээн зохион байгуулах ажлын хэсэг цаг тухайд нь шийдвэрлэнэ.

8.2. Сугалааны үр дүнг үндэслэн хэсгийн хуваарилалт болон тоглолтын дарааллыг зохион байгуулагч тогтооно.

8.3. Баг, тамирчид хуваарьт тоглолт болох цагтаа ирээгүй бол 5 минут хүлээх бөгөөд дээрх хугацаанд амжиж ирээгүй тохиолдолд тухайн тоглолтод хожигдсоноор тооцно.

8.4. Тэмцээний явцад тэмцээний талаар болон өөр бусад асуудлаар маргаан гаргахгүй байх, шүүгчтэй маргалдахгүй байх /Шүүгчийн гаргасан шийдвэр эцсийнх байна./

8.4. Баг, тамирчид өөрийн багийг дэмжихээр хүрэлцэн ирсэн хөгжөөн дэмжигчдийн зохион байгуулалтыг хариуцан аливаа зүй бус үйлдэл гаргуулахгүй байх

8.5. Баг, тамирчид болон хөгжөөн дэмжигчид бусдын нэр төр, алдар хүндийг гутаан доромжлох, тоглолтын үед хараал хэлэхийг хатуу хориглоно.

8.6. Тэмцээний үед удирдамжид заасан дэг журам болон зохион байгуулагчдын зүгээс тухайн үед тавьсан шаардлагыг биелүүлээгүй баг, тамирчдад нэг удаа сануулах арга хэмжээ авах бөгөөд дахин зөрчил гаргавал тухайн багийг тэмцээнээс хасах хүртэл арга хэмжээ авна.

ХЯНАСАН:
СПОРТ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА




Г.ЦОЛМОНБЯАР

ЗХНХ-Н ДАРГА



Б.ЛХАГВАБААТАР

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Х.ЭРДЭНЭБЯАР